

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР
ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ (2026 оны эхний хагас жилийн байдлаар)**

Нийгмийн даатгалын ерөнхий газар

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт түвшин	Хүрсэн түвшин (хүрээгүй бол шалтгаан, нөхцлийг тайлбарлах)	Гүйцэтгэлийн хувь
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
2.1. ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ ХҮН								
2.1.1	Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого							
2.1.1.1	2.1.1.1. Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулж, иргэн бүрд хуримтлалын сан бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах боломжийг бүрдүүлнэ..							
	1	Хагас хуримтлалын тогтолцоонд шилжих шинэчлэлийг үргэлжлүүлж тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг хуримтлуулах;	Улсын төсөв Бусад эх үүсвэр 459,504	Тухайн жилийн хуримтлуулсан шимтгэл, хувь	-	2	Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар даатгуулагчийг бодитой хуримтлалтай болгох эрх зүйн шинэчлэл хийж, тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжихээр зохицуулсан. Энэ зорилтын хүрээнд 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 1,350.3 мянган даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг мөнгөжүүлэн нийт 416.7 тэрбум төгрөгийг тэтгэврийн нөөц санд байршуулснаас 85.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын үнэт цаас, 215.3 тэрбумыг банкны системд нөлөө бүхий арилжааны банкууд (ХААН, ХХБ, Төрийн банк, Голомт банк)-д мөнгөн хадгаламж хэлбэрээр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж 116.4 тэрбумын үлдэгдэлтэй байна. Үүний дүнд нөөц сангийн хөрөнгө 2026 оны эхний хагас жилийн байдлаар 16.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.	90
	2	Нийгмийн даатгалын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж,	Улсын төсөв (1,515,232.2)	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	-	-	Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд нэмэлт оруулах саналыг танилцуулгын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/301 дүгээр албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг ажлын	90

		Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;				өдрөөр олгох нэмэлт оруулах саналыг танилцуулгын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/610 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 3.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/788 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 4.Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсөвт өөрчлөлт оруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/904 дүгээр албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 5.Батлан хамгаалах яамнаас Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалттай ижил агуулга бүхий нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар боловсруулж байгаатай холбогдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт оруулах дагалдах хуулийн төслийн саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/1229 дүгээр албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 6.Монгол Улсын Засгийн газраас 2026.03.17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах, хууль батлуулахад шаардлагатай тооцоолол хийхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллав. 7.Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт	
--	--	---------------------------------------	--	--	--	---	--

							оруулах тухай хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах, шаардлагатай тооцооллыг хийхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газартай хамтран ажиллав. Уг хуулийн төсөлд тэтгэврийн тогтолцоонд өөрчлөлт оруулж даатгуулагч улсын төсвөөс олгох баталгаат тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсанаар даатгуулагч санхүүгийн олон эх үүсвэрээс тэтгэвэр авахаар тусгасан болно. 8.Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой 9 төрлийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой 9 төрлийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой 2 төрлийн, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт холбоотой 2 төрлийн, нийт 22 төрлийн тооцоо, судалгаагаар нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад нөлөөлөх нөлөөллийг тооцож, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/1174 дүгээр албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 9.Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газартай хамтарсан ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төслийн дагалдах 29 тооцооллыг хийж, нягтлан нэгтгэв.	
2.1.1.22.	3	Тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 365724.3	Нийгмийн даатгалын тэтгэврийн нэмэгдэл, хувь	14.6	6.5	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцийн жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 2025 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 242 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэврийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 80,000 төгрөгөөр нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 769.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон	100

							тэтгэврийн доод хэмжээг 652.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон байна. Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 524.8 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлж, тэтгэврийн нэмэгдэлд 478.0 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвт тусгасан байна.	
2.1.3.Нийгмийн баталгаа								
2.1.3.1	Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж, Үндэсний баялгийн сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, "E-Mongolia" платформоор дамжуулан иргэн бүрд хуримтлалын данс нээнэ.							
2.1.3.2	4	Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх;	Бусад эх үүсвэр 2,634.10	Үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгж, байгууллагын тоонд нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь	58.6	62.3	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/19 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалд 2026 онд хамруулах ажил олгогч, албан журам, сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.Нийгмийн даатгалд 2026 онд хамруулах ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тооны төлөвлөгөөг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлж, хэрэгжилтэд сар бүр хяналт тавин ажиллаж байна. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2026 оны 1 дүгээрр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 117.3 мянга, ажиллах хүч 1,437.3 мянган хүн, 2025 оны жилийн эцсийн байдлаар малчдын тоо 313.1 мянга байна.	78,5
				Нийт ажиллах хүчинд даатгуулагчийн эзлэх хувь	81	82.7	Нийгмийн даатгалын байгууллага 2026 оны эхний хагас жилийн байдлаар 3.3 мянган ажил олгогч, 19.1 мянган албан журмаар даатгуулагч, 4.1 мянган сайн дураар даатгуулагч, үүнээс 2.5 мянган малчныг нийгмийн даатгалд шинээр хамруулсан.	
				Нийт малчны тоонд нийгмийн даатгалд хамрагдсан малчны эзлэх хувь	21	24	Нийгмийн даатгалын сангийн 6 сарын мэдээгээр нийт 60.2 мянган ажил олгогч, 971.6 мянган даатгуулагч, 53.9 мянган малчныг нийгмийн даатгалд хамруулсан байна. - Аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь 51.3 хувь; - Даатгуулагчийн эзлэх хувь-67.5 хувь; - Малчнаар даатгуулагчдын эзлэх хувь-17.2 хувь байна.	
		5	Нийгмийн даатгалын үйлчилгээг их өгөгдөлд	Улсын болон орон нутгийн төсөв	Цахимжуулах үйлчилгээ, өссөн дүнгээр	24	27	Нийгмийн даатгалын 36 үйлчилгээнээс 29 үйлчилгээг бүрэн цахимжуулаад байна.

		суурилан бүрэн цахимжуулж, тоног төхөөрөмжийг шинэчлэх;	7,500.0			Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд эхний хагас жилийн байдлаар дараах ажлуудыг хийж байна. Үүнд: - Нийгмийн даатгалын сангаас олгох энгийн, олон хүүхэдтэй эхийн өндөр насны тэтгэврийн хүсэлтийг цахимаар гаргах бодлогын даалгавар боловсруулж Мэдээллийн технологийн төвд хүргүүлж, Portal.ndaatgal.mn системийн хөгжүүлэлт хийгдэж байна. - Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж авах хүсэлтийг https://portal.ndaatgal.mn/ системээр дамжуулан тухайн даатгуулагчийн гэр бүлийн гишүүд цахимаар гаргах боломжийг бүрдүүлж, 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлэв. Дээрх үйл ажиллагааг цахимжуулснаар иргэд, даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагад биечлэн ирэлгүйгээр, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хүсэлтээ цахимаар түргэн шуурхай гаргаж, үйлчилгээ авах боломж бүрдэв. - Ажил олгогч болон даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлээ нэхэмжлэлд суурилан цахимаар төлөх боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд төлбөрийн нэхэмжлэл үүсгэх, төлбөрөө цахимаар төлөх, төлөлтийн мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд бодит цагийн горимоор бүртгэх системийн хөгжүүлэлтийн ажил хийгдэж байгаа бөгөөд банкуудтай хамтран систем хоорондын мэдээлэл солилцоо, интеграцийн хөгжүүлэлт болон туршилтын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. - Даатгуулагч өөрөө өндөр насны тэтгэврийн хэмжээг урьдчилан тооцоолох цахим үйлчилгээг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэв. Уг үйлчилгээ нь нийгмийн даатгалын мэдээллийн санд бүртгэлтэй даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацаа, цалин хөлсний мэдээлэлд үндэслэн тэтгэврийн хэмжээг системээр тооцоолох боломжийг бүрдүүлэв. Түүнчлэн даатгуулагч өөрийн шимтгэл төлж ажилласан жил, тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг системд өөрчлөн оруулж, ирээдүйд авах тэтгэврийн хэмжээг тооцоолох боломжтой болж иргэд, даатгуулагч тэтгэврийн эрх үүсэх хугацаа, тэтгэврийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлсийг урьдчилан үнэлэх нөхцөлийг бүрдүүлэв.	
--	--	---	---------	--	--	--	--

Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болгож, тэтгэврийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.								
2.1.3.3	6	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болгож, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх;	"Улсын төсөв, Бусад эх үүсвэр" 1,917,465.30	Хуримтлалтай болсон даатгуулагч, мянган хүн	-	1,438	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар зохицуулсан. Энэ хуульд заасны дагуу Засгийн газрын 2024 оны "Журам батлах тухай" 256 дугаар тогтоолоор "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө, төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, хяналт тавих журам"-ыг баталсан. Эдгээр эрх зүйн баримт бичгийн хүрээнд тэтгэврийн нөөц санд мөнгөн хөрөнгө байршуулах тооцолол хийн, холбогдох саналыг боловсруулж, 2026 оны эхний хагас жилд 100.0 тэрбум төгрөгийг байршуулж даатгуулагчдад мэдээлэх ажлыг Мэдээллийн технологийн төвтэй хамтран зохион байгуулав. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дэх хэсэгт заасны дагуу тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулан сангийн хөрөнгийг өсгөн аливжуулав. Үүнд: 1.Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр банкны системд нөлөө бүхий арилжааны 4 банканд байршуулан өгөөжийн тооцоог гарган сар бүр арилжааны банкттай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулан ажиллав. Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг мөнгөн хадгаламжид хөрөнгө оруулсны өгөөжийг сар бүрийн эцэст хүлээн авахаар гэрээнд тусгасан ба хугацааны эцэст 32.5 тэрбум төгрөгийн өгөөж хүртэх ба оны эхний хагас жилийн байдлаар 16.2 тэрбум төгрөгийн өгөөж хүлээн аваад байна. 2.Тэтгэврийн нөөц сангийн мөнгөн хөрөнгөөс Засгийн газрын дотоод үнэт цаас 85.0 тэрбум төгрөгөөр худалдан авч мэдээллийг шилэн дансанд оруулав. Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулсны өгөөжөөс хугацааны эцэст 35.6 тэрбум төгрөг хүлээн авч сангийн хөрөнгийг нэмэгдүүлнэ. Гэрээнд хагас жил тутам хүү авахаар заасан тул одоогоор хүүгийн өгөөж хүлээн аваагүй болно. Тэтгэврийн нөөц сангийн үлдэгдэл 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 116.4 тэрбум төгрөг /харилцахын дансны үлдэгдэлд тооцсон хүүг нэмж	93.9

						тооцсон/, хөрөнгө оруултад оруулсан дүнтэйгээ нийтдээ 416.7 тэрбум төгрөг байна. Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг даатгуулагч бүрээр бүртгэн мэдээллийг даатгуулагчдад “Нийгмийн даатгал” аппликейшн, https://portal.ndaatgal.mn/ системээр мөн E-mongolia апплекейшний “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал” цэсээр нийтэд ил тод мэдээлэн ажиллав.		
Хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хууль, эрх зүйн зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.								
2.1.3.4	7	Тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нарийвчлан тусгах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;		Арга хэмжээний хэрэгжилт, хувь	-	-	Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар даатгуулагчийг бодитой хуримтлалтай болгох эрх зүйн шинэчлэл хийж, тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжихээр зохицуулсан. Энэ зорилтын хүрээнд 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 1,350.3 мянган даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг мөнгөжүүлэн нийт 416.7 тэрбум төгрөгийг тэтгэврийн нөөц санд байршуулснаас 85.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын үнэт цаас, 215.3 тэрбумыг банкны системд нөлөө бүхий арилжааны банкууд (ХААН, ХХБ, Төрийн банк, Голомт банк)-д мөнгөн хадгаламж хэлбэрээр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж 116.4 тэрбумын үлдэгдэлтэй байна. Үүний дүнд нөөц сангийн хөрөнгө 2026 оны эхний хагас жилийн байдлаар 16.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт “даатгуулагч нас барвал түүний мөнгөжүүлсэн орлогыг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ” гэж заасны дагуу даатгуулагч нас барвал түүний мөнгөжүүлсэн орлогыг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлэх бөгөөд мөн хуулийн 29.7 дахь хэсэгт “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож, үлдэгдлийг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.” гэж заасны дагуу нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт	90

							зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож, үлдэгдлийг мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 29.6 дахь хэсгийг 2030 оноос эхлэн хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 2030 оноос эхлэн нас барсан даатгуулагчийн хууль ёсны өв залгамжлагчид Иргэний хууль болон Нотариатын тухай хуульд заасны дагуу өвлүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлж эхлэнэ.	
<i>Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ.</i>								
2.1.3.5	8	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх хуулийн төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлэх;		Арга хэмжээний хэрэгжилт, хувь	-	-	Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах, хууль батлуулахад шаардлагатай тооцоолол хийхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллав. Мөн Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах, шаардлагатай тооцооллыг хийхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газартай хамтран ажиллав. Уг хуулийн төсөлд тэтгэврийн тогтолцоонд өөрчлөлт оруулж даатгуулагч улсын төсвөөс олгох баталгаат тэтгэвэр, тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсанаар даатгуулагч санхүүгийн олон эх үүсвэрээс тэтгэвэр авахаар тусгасан болно. Мөн Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой 9 төрлийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой 9 төрлийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой 2 төрлийн, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт холбоотой 2 төрлийн, нийт 22 төрлийн тооцоо, судалгаагаар нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад нөлөөлөх нөлөөллийг тооцож,	90

						НДЕГ-ын 2026 оны 01/1174 дүгээр албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газартай хамтарсан ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төслийн дагалдах 29 тооцооллыг хийж, нягтлан нэгтгэв.	
Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулна.							
2.1.3.6.	9	Засгийн газар хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шинээр байгуулах;		Байгуулсан хэлэлцээр, өссөн дүнгээр	6	- Монгол Улс нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах 7 улстай байгуулсан Хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав. Үүнд: 1.БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хүрээнд ОХУ-д ажилласан хугацаагаа баталгаажуулах хүсэлт гаргасан 38 хүний хүсэлтийг ОХУ-ын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлж, хоёр улсад ажилласан хугацаагаа баталгаажуулахаар хүсэлт гаргасан 25 хүний ажилласан жилийн тодорхойлолтыг баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлж, 8 хүнд хэлэлцээртэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөв. 2.БНСУ, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хүрээнд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанд шимтгэл төлсөн 20 хүний 69.8 сая вонны шимтгэлийн буцаан олголтын нэхэмжлэх, баримт бичгийг хүлээн авч Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлэв. Мөн хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажилласан иргэдийн тэтгэвэрийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх чиглэлийг БНСУ дахь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасагт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. 3.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Чех Улсад тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 52 хүний Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан тухай лавлагаа, 21 хүний Бүгд Найрамдах Чех Улсад даатгалд хамрагдсан хугацааны гэрчилгээний хүсэлтийг БНЧУ-ын талд хүргүүлэв. 4.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Унгар Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд тус улсаас тэтгэвэр	100

							тогтоолгохоор хүсэлт гаргасан болон мэдээлэл солилцох 19 хүний, Монгол Улсад шимтгэл төлж ажилласан жилийг баталгаажуулах 13 хүний маягтын дагуу, Унгар улсаас өндөр насны тэтгэвэр авагч 30 хүний оршин суугаа газрын хаягийн баталгаажуулалтыг Унгар Улсын талд хүргүүлэв. 5.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Польш Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 7 хүний мэдээллийг Польш Улсын талд хүргүүлэв. 6.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд 1 хүний мэдээллийг Бүгд Найрамдах Турк Улсын Нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэв. 7.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хүрээнд Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улсад 1998 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө шимтгэл төлж, ажилласан 97 хүний мэдээллийг маягтын дагуу Бүгд Найрамдах Казахстан Улсын холбогдох мужуудын тэтгэврийн асуудал хариуцсан байгууллагуудад хүргүүлэв. 8.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг 2026.04.01-нээс эхлэн хэрэгжүүлэхтэй холбоотой тус улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хангамж, нийгмийн даатгалын газрын Орлогч дарга Хасенова Баян Зарлыковнатай 2026.03.26-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад оролцов. Уулзалтаар талууд Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлын явцын талаар харилцан мэдээлэл солилцов. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг хэрэгжилтийг зохион байгуулах зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.	
2.1.3.7	Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгоно.							
10	Нийгмийн даатгалын		Нээлттэй байршуулсан	Нийгмийн даатгалын	100	1. www.shilen.gov.mn	100	

		сангийн мэдээллийг нээлттэй байршуулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах;		мэдээлэл, хувь	сангийн мэдээллийг www.shilen.gov.mn вебсайтад нийтэлж байна.	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, мөнгөн хөрөнгийн мэдээллийг www.shilen.gov.mn цахим хуудаст байршуулав. 2. <u>www.opendata.gov.mn</u>: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн Газрын 2024 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу 2026 оны эхний хагас жилийн байдлаарх нээлттэй мэдээллийг тус бүр дөрвөн форматаар хувирган www.opendata.gov.mn болон www.ndaatgal.mn вэб сайтуудад цаг хугацаанд нь байршуулсан. 3. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, 2025 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлт, биелэлт, сар бүрийн сангийн болон урсгал үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийн мэдээг www.shilendans.gov.mn цахим хуудаст хуулийн хугацаанд байршуулав 4.Арилжааны банкуудтай байгуулсан мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болохтой холбогдуулан мөнгөн хадгаламж байршуулсан арилжааны банкуудтай хийсэн хэлцлийн үр дүнд хадгаламжийн жилийн хүүгийн хэмжээг Хаан банктай 15 хувиар, Худалдаа хөгжлийн банк болон Төрийн банктай 15.11 хувиар харилцан тохиролцож, гэрээнд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусган 2027 оны 05 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл нэг жилийн хугацаатайгаар сунгаж, "Мөнгөн хадгаламжийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ"-г байгуулан ажиллав. (Голомт банк 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хүүгийн хэмжээнээс доогуур буюу 14 хувийн хүүгийн санал ирүүлсэн тул тус банктай байгуулсан хадгаламжийн гэрээг сунгаагүй болно.) Холбогдох мэдээллийг https://shilendans.gov.mn/ сайтад байршуулав. Хугацааны эцэст Хаан банкнаас 43,455.0 сая, Худалдаа хөгжлийн банкнаас 26,623.8 сая, Төрийн банкнаас 11,438.3 сая, нийт 81,517.1 сая төгрөгийн хүүгийн орлогыг хүлээн
--	--	---	--	----------------	--	---

						авч, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн хөрөнгийг 43,455.0 сая, тэтгэмжийн даатгалын сангийн хөрөнгийг 38,062.1 сая төгрөгөөр тус тус өсгөн нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэв. Гэрээнд заасны дагуу 2026 оны 05 дугаар сард 6,700.0 сая төгрөгийн хүүгийн орлогыг хүлээн авч, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 2026 оны эхний хагас жилд 13,400.1 сая төгрөгийн хүүгийн орлогыг хүлээн авахаар байна. Үнэт цаасны болон хадгаламжийн хүүгийн орлого хүлээн авсан мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудаст нийтэлж, олон нийтэд мэдээлж ажиллав. Дээрх мэдээллийг www.ndaatgal.mn вэб, shilen.dans.gov.mn цахим хуудас, байгууллагын цахим хуудас, фэйсвүүк, пэйж хаягаар мэдээлж ажиллав.	
3.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
3.1.ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ							
3.1.3.Банк, санхүү, даатгалын салбарын шинэчлэл							
3.1.3.6	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, тэтгэврийн нөөц сан, хувийн нэмэлт тэтгэврийн сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг эрх бүхий мэргэжлийн байгууллагын менежментээр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.						
3.1.3.6	11	Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өсгөх, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийг нэмэгдүүлж холбогдох хуульд нэмэлт оруулах;		Арга хэмжээний хэрэгжилт, хувь		“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ахмад настныг тэтгэврийн олон эх үүсвэрээс орлоготой болгох, ирээдүйд авах тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1.Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах, хууль батлуулахад шаардлагатай тооцоолол хийхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллав. Хууль батлагдсанаар ахмад настан улсын тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авахаас гадна нэмэлтээр хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, орлого нь нэмэгдэх, хувийн тэтгэврийн сангууд бий болсноор эдийн засагт хөрөнгө оруулалтын урт хугацааны санхүүгийн эх үүсвэр бий болох, хөрөнгийн зах зээлийг дэмжих, ажил олгогчид ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдэх юм.	90

						2.Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах, шаардлагатай тооцооллыг хийхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллав. Хуулийн төсөлд даатгуулагч сайн дурын үндсэн дээр хуримтлалын тэтгэвэрт хамрагдах, тэтгэврийн мөнгөн хуримтлал бүрдүүлэх, хөрөнгө оруулалтад оруулах, өвлүүлэх, хөрөнгө оруулалтын удирдлагыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн байгууллага болон тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийн тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар гэрээний үндсэн дээр хөрөнгийн үйл ажиллагааг эрхлэхээр тусгагдсан. Хууль батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, даатгуулагчийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын хөрөнгийн тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын эрх бүхий мэргэжлийн байгууллагаар уудирдуулан хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулснаар нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.	
3.2.БИЗНЕС, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН							
3.2.1.Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл							
3.2.1.5.	Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлнэ.						
3.2.1.5	12	Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дарамт нэмэхгүйгээр ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг		Арга хэмжээний хэрэгжилт, хувь		“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах, шаардлагатай тооцооллыг хийхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газартай хамтран ажиллав. Уг хуулийн төсөлд ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл төлөх цалин хөлсөнд дээд хязгаар тогтоох, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор ажил олгогчийн төлөх зарим төрлийн даатгалын шимтгэлийг тодорхой хугацаанд чөлөөлөх, ажил олгогчийн үйлдвэрлэлийн осол,	90

		холбогдох хуульд нэмэлтээр оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх					мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувийг бууруулах, сайн дурын үндсэн дээр хуримтлалын тэтгэвэрт хамрагдах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөх санхүүгийн хэрэгслийг нэмэгдүүлэх, оюутан, суралцагчид болон тэднийг ажиллуулж байгаа ажил олгогчийг зарим төрлийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх зэрэг зохицуулалт тусгагдсан. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар ажил олгогчид ирэх санхүүгийн ачаалал багасаж, албан бус салбарт ажиллаж байгаа иргэд нийгмийн даатгалд хамрагдсан тохиолдолд шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх, гарааны бизнес эрхлэгчдийг зарим төрлийн даатгалын шимтгэлийг тодорхой хугацаанд чөлөөлөх, оюутан, залуучууд ажил хөдөлмөр эрхэлсэн тохиолдолд зарим даатгалын төрлийн шимтгэлээс чөлөөлөх хууль эрх зүйн орчин бүрдэнэ.	
3.2.1.6. Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.								
3.2.1.6	13.	Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлэх		Арга хэмжээний хэрэгжилт, хувь			Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, төсөл боловсруулах, шаардлагатай тооцооллыг хийхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газартай хамтран ажиллав. Уг хуулийн төсөлд ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээгээр ажил эрхэлж байгаа ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг уян хатан нөхцөлөөр төлүүлэх зохицуулалт тусгагдсан болно. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар ажил олгогч, даатгуулагчийн санхүүгийн ачаалал буурч, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	90
НИЙТ ДУНДАЖ								91.7